

МОНГОЛ УЛСЫН БАРУУН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Аялал, жуулчлалын салбарын хөгжил

Үндэслэл: Баруун бүсэд унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт сүрлэг байгаль, олон үндэстэн ястны өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд зэрэг дотоод, гадаадын зочид жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна. “Аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-нд баруун бүсийг байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх сонирхол татахуйц бүс болгохоор тусгажээ. 1966 онд ЮНЕСКО-гоос Ховд хотын дэргэдэх Ямаат-Улаан гэдэг нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй, мөн дархан цаазат Отгонтэнгэр уулыг “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэж авсан байна. Мөн 1997 онд Увс нуурын ай савын Дархан цаазтай газрыг дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамруулан авчээ. Улаангом хотын дэргэдэх Чандмань Улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог. Эдгээрийг дэлхий дахинд өргөн сурталчилж, жуулчдын сонирхлыг татах олон талт ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, баруун Монголын олон ястны амьдрал ахуй зэргийг сонирхуулах өргөн боломжтой. Зэгс, хулсан шагшуурга дунд завиар аялан, ховор жигүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна. Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай Таван богд, Цамбагарав, Цэнгэл хайрхан, Мөнх хайрхан, Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа зэрэг өндөр уулсад уулын спорт, Тэс Түргэн, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голуудаар, мөн Ховд аймгийн Хар-ус нуурын хойд эргээр усан спорт хөгжүүлэх боломж бас байна. Баруун бүсэд түүх-археологийн болон шашин угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна.

Иймд Баруун бүсэд төрөл бүрийн аялал жуулчлалыг үндсэн ба туслах маршрутаар хөгжүүлж, эдийн засагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг салбар болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат / 2006-2010он/ :

Тэргүүлэх зорилт 1. Баруун бүсэд аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хөгжүүлэх
- Эхний ээлжинд Ховд-Хар-ус нуурын орчимд аялал жуулчлалын цогцолбор байгуулан уулын аялал, усан болон морин спортыг хөгжүүлэх
- Дотоод гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглийн зочид буудал, жуулчдын бааз, дэн буудлын сүлжээ байгуулах
- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах
- Байгаль орчинд хоргүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах
- Аялал жуулчлалын чиглэлээр гадаадын сонирхогч томоохон компаний хөрөнгө оруулалтыг татан оруулах арга хэмжээг зохион байгуулах
- Дотоодын аялал жуулчлал хөгжүүлэх үүднээс юуны өмнө дотоодын амрагчид хүлээн авч байгаа Ховдын Хар-ус нуурын жуулчдын бааз, Увс нуурын ай сав дахь Хархираа зэрэг амралт, жуулчлалын төв, Цүнхэгийн амралт, Хяргас нуурын хөвөөн дэх Хар тэрмисийн рашаан сувиллын газар, Завханы Отгонтэнгэрт буй рашаан сувиллын газар, Говь-Алтай дахь Бигэрийн бөөрний сувилал, Хүнхэрийн рашаан сувилал зэрэг амралт сувиллын газруудыг тохижуулж, хүчин чадлыг нь бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэх

Гарах үр дүн: Аялал жуулчлалын салбар түргэн хурдацтай хөгжих үндэс суурь тавигдаж, эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувиллын газруудыг тохижуулж, музейн үзмэрүүдийг баяжуулах арга хэмжээ авах

- Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх
- Аймгийн төвүүдийн угсаатны зүйн музейнүүдийг засварлаж, музейн сан хөмрөгийг арвижуулах
- Аялал жуулчлалын бүсүүдийг дотоодын болон олон улсын мэдээллийн сүлжээнд оруулж, зах зээлийн сурталчилгааг оновчтой хийх
- Аялал жуулчлалын маршрутын дагуухь түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг идэвхжүүлэх
- Зочид буудал, ангийн отог, зоогийн газар зэрэг үйлчилгээний газруудыг өргөтгөн тохижуулах
- Аялал жуулчлалын отог баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэлжилтэй боловсон хүчин бэлтгэх
- Жуулчдын бааз, амралт сувиллын газрууд, аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажилладаг нөхцөл бүрдүүлэх

Гарах үр дүн: дотоод, гадаадын жуулчдын хэрэгцээ, сонирхолд нийцэхүйц материаллаг бааз бий болон, аялал жуулчлалын менежмент сайжирна.

Хоёрдугаар үе шат /2011-2015 он/:

Тэргүүлэх зорилт1. Аялал жуулчлалын салбарыг бүсийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Ховд-Хар-Ус нуурын орчимд байгуулсан аялал жуулчлалын цогцолборыг Баруун бүсийн загвар бааз болгон хөгжүүлэх
- Баян-өлгий аймаг дахв чулуун галерей гэж нэрлэгдэх арваад мянган бул чулуунд сийлсэн 70 гаруй мянган зурагтай “Бага Ойгорын хадны сүг зураг” Алтайтаван богд, Цамбагарав, Цэнгэлхайрхан, Мөнххайрхан зэрэг мөнх цаст уулсын чиглэлээр аяллын маршрутууд гарган аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх
- Говь-алтайг байгалийн шинжлэл, рашаан сувиллын бүс нутгийн жишгээр хөгжүүлэх зорилт тавин Алтай хот-Бигэр-Цагаан хаалганы хүрхрээ –Ээж хайрхан уул-Их говийн дархан газрын чиглэлд / 600 орчим км/ , Алтай хот-Шарга-Цагааннуур-Гурван уул-Тахийн талын чиглэлд / 700 км/ гэсэн маршрутаар экотуризм хөгжүүлэх энэ зорилгоор Алтай хотод олон улсын зэрэглэлийн зочид буудал, Эрээн нуур, Төгрөг, Ээж хайрхан уулын ойролцоо улирлын чанартай жуулчдын баазыг байгуулж эхлэх
- Завхан аймагт Отгонтэнгэр, Булнай, Хангайн нурууны өндөр уулс, Их монголын элсэн манхан, Завхан, Идэр, Тэсийн түргэн урсгалт голууд , Отгон, Тэлмэн,Түдэвтэй сумын үзэсгэлэнт газрууд болон нуруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз, отгууд байгуулах
- Увс аймагт эртний Түрэг-Монголын хүн чулуунууд, үзэсгэлэнт газар нутгаа ашиглан Дархан цаазат газрын бүс, Хяргас-Айргийн хоолойн бүс, Говь-хангайн хосломол маршрут, Уулын спорт-аяллын бүс, ангийн отгууд бүхий бүсүүдээр төрөлжүүлэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх
- Ази Европ, Номхон далайн орнуудад нэн түрүүнд сурталчлах замаар энэ бүс нутгийг олон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулах арга хэмжээ авах

Гарах үр дүн: Баруун бүсийн аялал жуулчлалын үндсэн чиглэлүүдээр аялах амрагч, жуулчдын олшрон, бүсийн эдийн засгийн өсөлтэд энэ салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, Менежментийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Баруун бүсийн аймгуудын олон ястны соёл урлаг, ардын өв уламжлалыг харгалзан бүсийн тулгуур төв-Ховд, Улиастай хотод баруун бүсийн соёл урлагийн болон спортын төв цогцолборуудыг барих
- Аялал жуулчлал хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийн дагуу орчин үеийн зочид буудал , жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний төрлийг олшруулах
- Шаардлагатай боловсон хүчнийг бүсийн төвүүдэд бэлтгэх арга хэмжээ авах
- Аялал жуулчлалд хөрөнгө оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих, жуулчдад хандсан сурталчилгааг өргөтгөх

Гарах үр дүн: Баруун бүсийн эдийн засагт аялал жуулчлалын салбар тэргүүлэх үүрэгтэй болсон байна.

МОНГОЛ УЛСЫН ХАНГАЙН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЛБӨР

Аялал жуулчлалын хөгжил

Үндэслэл. Хангайн бүс нь түүх, соёлын дургалт болон байгалийн үзэсгэлэнт газрууддаа түшиглэн дотоод, гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх маш тохиромжтой нутаг юм.

Хөвсгөл аймагт байгалийн шинжлэл, амралт, шашин, соёл, спортын болон өвөрмөц сонирхлын, Орхон,Булган аймагт бизнес, амралт сувилал, спортын болон морин аяллын, Архангай, Өвөрхангай аймагт түүх, соёл иргэншил, байгаль судлал, амралт сувилал, морин аяллын, Баянхонгор аймагт рашаан, сувилал, спорт аяллыг түлхүү хөгжүүлэх боломжтой байна.

Мөн одоо бүрдээд байгаа материаллаг бааз дээрээ түшиглэн тэдгээрийг өргөтгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар бүсийн аймгуудыг хамарсан аялал жуулчлалын сүлжээ байгуулах, уг сүлжээг ОХУ-ын Байгаль нуур болон Өвөр монголын аялал жуулчлалын сүлжээнд холбох, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх нь тулгамдсан асуудал болж байна.

Нэгдүгээр үе шат / 2006-2010он/

Тэргүүлэх зорилт. Хангайн бүсэд аялал жуулчлалын салбарт оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, менежментийг нь сайжруулах замаар бүсийн аялал жуулчлалын сүлжээ байгуулж, стандартын шаардлагыг өндөржүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд холбоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Хангайн бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, Хархорин, Тариат, Хөвсгөл нуур, Булган зэрэг аялал жуулчлалын бичил бүсүүдийг хамруулан цогцолбороор хөгжүүлэхийг дэмжих
- Хархорины аялал жуулчлалын цогцолборын хүрээнд Эрдэнэ зуу хийдийг сэргээн засварлах, жуулчдыг хүлээн авах төвийг байгуулах, эртний нийслэл Хархорум хотын туурь дээр ил музей байгуулах, улсын төв музейн салбарыг байгуулах, Хөшөө цайдамд жуулчид хүлээн авах байр барих, Хужирт,Бат-өлзий, Цэнхэр, Хотонд сумын халуун рашаанууд болон Улаан цутгалан, Үүртийн тохой, Өгийнуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн гадаад, дотоодын жуулчид хүлээн авах үйлчилгээний газруудыг бий болгох, Шанхын баруун хүрээ, Төвхөн хийд, Цэнхэрийн цагаан сүм, Харбалгас зэрэг түүх, шашин, соёлын дурсгалт газруудыг жуулчдад үйлчлэх түвшинд хүргэн тохижуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах
- Булган аймагт өвлийн амралтын аяллыг хөгжүүлэх, элсэн тасархай, Хөгнө хан уулын орчимд олон улсын аялал жуулчлалын хотхон байгуулах
- Хөвсгөл нуурын орчимд аялал жуулчлалын цогцолбор / аялын чиглэл, замын тэмдэгжүүлэлт, амралтын түр буудал, үйлчилгээний цэгүүд бүхий/ байгуулах үндэс суурийг тавих
- Улаанбаатар-Цогт хун тайжийн цагаан балгас-Хөгнө хан-Хар бухын балгас-Могодын халуун рашаан-Өгий нуур-Хархорин-УБ чиглэлийн аялал жуулчлалын маршрут гаргах
- Улаанбаатар-Булган-Баян-Агтын, Хануй-Шарга-Цэгээн нуур- Архангайн Тариат-рашаант-УБ чиглэлээр аялал жуулчлалын маршрут гаргах
- Улаанбаатар-Булган-Эрдэнэт- Амарбаясгалант хийд-Булган-Архангай-Эрдэнэзуу-УБ чиглэлээр аялал жуулчлалын маршрут гаргах
- Хангайн бүс нутгийн байгалийн үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр, байгаль орчинд хоргүйгээр зохистой ашиглах, үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх
- Аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ холбогдуулан авто замын сүлжээ, цахилгаан дамжуулах шугам, мэдээлэл холбооны сүлжээ бий болгох, бага даацын онгоцны буудал барих, жуулчдын хүлээн авах өндөр зэрэглэлийн зочид буудлын тоог нэмэгдүүлэх, зэрэглэлийг нь дээшлүүлэх
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, сурвалжлан олох, сурталчилгаа мэдээллийг өргөжүүлэх
- Бүсийн аялал жуулчлалын менежментийн асуудал эрхэлсэн байгууллыг байгуулах
- Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтын дэмжих
- Аялал жуулчлал эрхэлж байгаа аж ахун нэгж , иргэдийн татварын орлогыг тухайн орон нутагт оруулах, татвар төлөлтөд тавих хяналтыг сайжруулах
- Жуулчны баазуудын материаллаг бааз, үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх, аяллын сүлжээний дагуу шинээр жуулчны бааз байгуулах, зочид буудлын сүлжээнд холбогдохыг зээлийн бодлогоор дэмжих
- Жуулчны урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ-ын аялал жуулчлалын зах зээлийг холбосон сүлжээ бий болгох

Гарах үр дүн. Аялал жуулчлалын салбарын бүсийн дотоод нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жинг 12 хувьд хүргэнэ.

Хоёрдугаар үе шат / 2011-2015 он/ :

Тэргүүлэх зорилт. Аялал жуулчлалын бүх төрлийг хөгжүүлж, бүсийн эдийн засагт салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, менежментийг нь олон улсын стандартын түвшинд хүргэж сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүсийн аялал жуулчлалын сүлжээ бий болгох төслийг бүрэн хэрэгжүүлэх
- Улаанбаатар-Хархорин-Цэцэрлэг-Мөрөн-Хатгал-Дархадын хотгор гэсэн аялал жуулчлалын маршрутын үйл ажиллагааг жигдрүүлэх
- Жуулчдын сонирхлыг татах боломжийг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн спортын үйл ажиллагааг / морь унах, автомашинаар аялах, уулын бартаат замаар дугуйгаар аялах, агаарын бөмбөрцөгөөр нисэх, шүхрээр буух, агаарын чөлөөт уналт, дельтопланаар нисэх, завь салаар аялах, загас барих г.м/ сонирхсон аялал жуулчлалын нэр төрлийг олшруулах
- Байгалийн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх
- Бүсийн хэмжээнд байгаа халуун, хүйтэн рашааныг түшиглэн олон улсын эмчилгээ, сувиллын төвүүдийг байгуулах
- Жуулчдын жилийн 4 улиралд хүлээн авах боломжтой олон улсын жишиг, стандартад нийцсэн баазуудыг байгуулах
- Аялал жуулчлалын сүлжээг өргөтгөж, төрлийг олшруулах
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг олшруулах
- Дотоодын аялал жуулчлалын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх
- Жуулчлалын мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх
- Аялал жуулчлал, амралт, рашаан сувиллын газрыг олон улсын жишгийн дагуу зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн дотоодын иргэд, байгууллагыг “Аялал жуулчлалын сан”-гаас урамшуулах арга хэмжээ авах
- Хөвсгөлийн үндэсний паркийн менежментийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

Гарах үр дүн. Аялал жуулчлалын салбарын бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жинг 20 хувьд хүргэнэ.

ТӨВИЙН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨТӨЛБӨР

Аялал жуулчлалын салбарын хөгжил

Үндэслэл: Төвийн бүсийн ойт хээр, тал хээр, говь хосолсон өвөрмөц экосистем, шашин, түүх, соёлын баялаг өв, тэдгээрийн аялал жуулчлалын үнэ цэнийг тодорхойлосны үндсэн дээр Сэлэнгэ, Дархан-уул, Дорноговь аймагт түүх, соёл, хот, суурин, худалдаа-бизнесийн чиглэлийн, Төв, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймагт амралт сувилал, спорт аялал, ардын урлаг / уртын дуу/, нүүдлийн соёл иргэншлийн чиглэлийн аялал жуулчлалын бүс нутгийг бий болгож, тэдгээрийг УБ-ын болон Хангайн бүсийн аялал жуулчлалын төвүүдтэй зам, тээвэр, холбоо мэдээлэл, маршрутын нэгдсэн сүлжээгэр холбон хөгжүүлнэ. Мөн аялал жуулчлалын салбарын маркетингийн нэгдмэл бодлогыг тодорхойлж, материаллаг баазыг нь сайжруулан, Улаанбаатар хот орчим, Горхи-Тэрэлж, Өмнөговь аймаг зэрэг олон улсын хэмжээний тэргүүлэх чиглэлийн аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулж, тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат / 2006-2010 он/:

Тэргүүлэх зорилт 1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг тууштай өсгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Төвийн бүсэд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловруулан хэрэгжүүлж эхлэх
- Аялал жуулчлалын чиглэлээр гадаадын томоохон компаниудын хөрөнгө оруулалтыг татан оруулахад онцгой анхаарч ажиллах
- Аялал жуулчлалын маршрутын дагуухь авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн салбаруудын хөгжлийн хөтөлбөр, мастер төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авах
- Аймгийн төвүүдийн угсаатны зүйн музейг засварлаж, музейн сан хөмрөгийг арвижуулах
- Аялал жуулчлалын лавлах, танилцуулга тогтмол гаргаж, интернетэд Вэб хуудас нээн ажиллуулах
- Аялал жуулчлалын маршрутын дагуухь түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх
- Түүх, соёл, шашны зан үйлийн бүс нутагт аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх
- БНХАУ-ын Цагаандэл, Өмнөговь аймгийн Шатын амны чиглэлд хилийн боомт нээх

- Өвлийн улиралд жуулчдыг татах зорилгоор тэмээний баяр, тэмээн поло тэмцээнийг зохион байгуулан тэмээн аяллыг өргөжүүлэх
- Зам харилцааны дагуу байдлыг ашиглан хот суурин-түүх соёлын аялал жуулчлалыг Сэлэнгэ-Дархан-уул- Алтанбулаг гэсэн маршрутаар хөгжүүлэх
- Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ, Орхон, Зэлтэр,Хүдэр, зэрэг мөрөн, голуудын сав нутагт аялал жуулчлалын, эмчилгээ сувиллын газар байгуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих, гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх нөхцөлийг хангах
- Аялал жуулчлалын бүс нутагт зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний газрыг шинээр байгуулахыг дэмжих
- Аялал жуулчлалын баазуудын менежментийг сайжруулах зорилгоор тэдгээрийн ажилтнуудыг төрөлжсөн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах
- Горхи-Тэрэлж-Налайх- Тоньюкүкийн хөшөө-Зуунмод-Манзуширийн хийд- Хустайн нуруу гэсэн маршрутын дагуу байгалийн болон түүх, соёлын аялал жуулчлалыг өргөтгөн хөгжүүлэх

Гарах үр дүн: Аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжих үндэс суурь нэмэгдсэн байна.

Хоёрдугаар үе шат / 2011-2015 он/

Тэргүүлэх зорилт 1. Аялал жуулчлалын салбарыг Төвийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аялал жуулчлалын бааз , төвүүдийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дэлхийн түвшинд хүргэх
- Аялал жуулчлалын цөм бүс нутгуудад өндөр зэрэглэлийн тохилог зочид буудлуудыг барихыг эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн дэмжих
- Ази Европын орнуудад сурталчлах замаар энэ бүс нутгийг олон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулах
- Чингис хааны амьдралын түүхтэй холбоотой “Буур хээр” –т жуулчны хотхон байгуулах, Сэлэнгэ-Байгаль нуур чиглэлээр аяллын маршрут гаргах
- Төвийн бүсийн аймгуудын олон ястны соёл, урлаг, ардын өв уламжлалыг харгалзан бүсийн тулгуур төв Зуунмод, Дархан хотод Төвийн бүсийн соёл урлагийн болон спортын төв цогцолбор, байгууламжуудыг барих

Гарах үр дүн: Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, бүсийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болно.

ЗҮҮН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Аялал жуулчлалын салбарын хөгжил

Үндэслэл: Зүүн бүс нутагт Хэнтий, Хянганы нуруу, Дорнод аймгийн хойд хэсэг болон Дарьгангын байгалийн цогцолбор газар, Мэнэнгийн тэгш тал, Буйр нуур, Хэрлэн, Онон, Хурх, Улз, Халх, голын сав нутгийн байгалийн үзэсгэлэнт нутаг, Гурваннуур, Хөдөө арал зэрэг Эзэн Чингис, Их хаадын түүх, үйл амьдралтай холбоотой газар нутаг, Чингисийн хөшөө, Их Бурхант, Хэрлэн Барс хотын туурь, Халх голын хөшөө дургалын цогцолбор зэрэг түүх, соёлын дурсгалт газар элбэг тул аялал жуулчлал, амралт сувиллыг хөгжүүлэх өргөн боломж байна,

Дундад зууны үеийн нүүдэлчин Монгол угсаатны түүх, соёлын дурсгал болох хүн чулуун хөрөг, урлал, эртний хүний булш, Бунхан, сүг зураг, зэрэг түүх, соёлын дурсгалт зүйлс ихтэй. Иймд энэ бүс нутагт аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх боломжтой юм.

Нэгдүгээр үе шат / 2006-2010 он/

Тэргүүлэх зорилт 1. Зүүн бүсэд аялал жуулчлалын цогцолборуудыг эрчимтэй байгуулж хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Зүүн бүсэд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх
- Аялал жуулчлалыг Хан Хэнтийн, Халх голын, Баян-уулын, Дарьгангын гэсэн 4 үндсэн маршрутын дагуу цогцолбороор хөгжүүлэх
- Судлан тогтоосны үндсэн дээр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт, Дадал сум болон Дорнод аймгийн хойд хэсгийг хамруулан “ Чингис хаан”-ы цуврал цогцолбор байгуулах ажлыг зохион байгуулж, Дорнод аймгийн Халх гол дахь хөшөө дурсгалын цогцолбор, Сүхбаатар аймгийн Алтан-овоо, Талын агуй,

Шилийн богдын орчмыг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран аялал жуулчлалын цогцолбор байгуулан хөгжүүлэх арга хэмжээ авах

- Аялал жуулчлалын цогцолборуудын дагуухь авто замыг сайжруулах ажлыг авто замыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх
- Хятадын Рашаан хот болон Дорнод аймгийн Сүмбэр орчмоор аялал жуулчлалын шинэ боомт нээх, түүний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх
- Хэнтий аймгийн Өмнөдэлэгр сумын Бэрээвин хийд, Дорнод аймгийн Халх гол сумын Их бурхант, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Егүзэрийн хийд зэрэг шашны зан үйлтэй холбоотой газар нутгийг бүсийн аялал жуулчлалын сүлжээнд оруулан хөгжүүлэх
- Аймгийн төвүүдийн угсаатны зүйн музейг засварлаж, хамгаалалт, дохиоллын орчин үеийн хэрэгслээр тоноглож, музейн сан хөмрөгийг арвижуулахын хамт жуулчдын сонирхлыг татах үзмэрийг шинээр бий болгох
- Зүүн бүсийн аялал жуулчлалын лавлах, танилцуулга, видео хуурцаг тогтмол гаргаж, интернетэд Вэб хуудас нээн ажиллуулах
- Аялал жуулчлалын маршрутын дагуухь түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг сайжруулах
- Зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний газрыг шинээр байгуулж, шинэчлэн тохижуулж, аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт ойртуулах
- Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор төрөлжсөн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах
- Ононгийн халуун ус, Аварга тосон, Жартал нуур, Гурваннуур, Ононгийн Тардын рашаан сувиллын сүлжээ байгуулах

Гарах үр дүн: Зүүн бүсэд аялал жуулчлалын 4 үндсэн цогцолборын үндэс суурь тавигдана.

Хоёрдугаар үе шат /2011-2015 он/

Тэргүүлэх зорилт 1. Байгалийн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Улсын аялал жуулчлалын мастер төлөвлөгөөтэй уялдуулан Дорнод Монголд байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловруулан хэрэгжүүлэх
- Хятад, Япон Солонгос, Европын орнуудад сурталчлах замаар энэ бүс нутгийг олон улсын болон Зүүн хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд хамруулах арга хэмжээ авах
- Эзэн Чингисийн онгоныг байгуулан, түүнийг тойрсон аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Хан Хэнтийн байгалийн үзэсгэлэнт газар, Нөмрөг, Ганга нуурын байгалийн цогцолбор, ан амьтныг харуулах зорилгоор аялал жуулчлалыг төрөлжүүлэн зохион байгуулах
- Өвлийн аялал жуулчлалын цогцолбор баазуудыг байгуулан Зүүн Хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд хамруулах арга хэмжээ авах

Гарах үр дүн: Аялал жуулчлалын 4 үндсэн цогцолборт байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн маршрутын үйлчилгээ бий болно.